

**МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ**

№ 16/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2015 оны 12 дугаар сарын 17, 22-ны өдрүүдэд нийт 2 удаа хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан явуулав.

2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (МБСГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөх хэд хэдэн хувилбар, тэдгээрийн үр дагаврын талаарх дараах асуудлуудыг авч хэлэлцэв.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2016 онд аажмаар сэргэх боловч Хятад, Оросын эдийн засаг саарсан хэвээр байна. Түүнчлэн АНУ-ын Бодлогын хүү өсөх хүлээлт нэмэгдсэн, Хятадын аж үйлдвэрийн өсөлт саарсан нь манай улсын экспортын гол түүхий эд болох алт, зэс, нүүрсний үнийн төсөөлөл дахин буурахад нөлөөллөө. Дэлхийн эдийн засгийн өсөлт, түүхий эдийн үнэ хүлээлтээс доогуур байгаа нь манай гадаад эрэлтийг бууруулж, дотоод эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.

Хөрөнгө оруулалт агшиж, гадаад худалдааны нөхцөл муудсан нь эдийн засгийн өсөлт 2015 оны туршид саарахад нөлөөлж, 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар өслөө. Уул уурхайн салбар сүүлийн улирлуудад тогтмол 10-аас дээш хувиар өсч байгаа боловч уул уурхайн бус салбар сүүлийн 2 улирал дараалан 1.2 хувиар агшжээ. Эдийн засагт уул уурхай, ХАА, бусад үйлчилгээний салбаруудын өсөлт эерэгээр нөлөөлсөн бол бүтээгдэхүүний цэвэр татвар, худалдаа, барилгын салбар сөрөг нөлөө үзүүллээ. Эрэлт талаасаа цэвэр экспортын өсөлт, өрхийн хэрэглээ нь өсөлтийг нэмэгдүүлсэн бол хөрөнгө оруулалт болон төсвийн зардал өсөлтийг бууруулах нөлөө үзүүлсэн. Эдийн засгийн өсөлт 2015 оны эцэст саарч 2%, Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2016 онд өсөлт эерэг буюу 2015 оны түвшинд хадгалагдахаар байна.

Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд үргэлжлэн буурч байгаа бөгөөд 2015 оны 10 дугаар сарын байдлаар М2 мөнгөний өсөлт -0.7 хувь, зээлийн өсөлт -7 хувь байна. Суурь төсөөллөөр жилийн инфляци 2015 оны эцэст 1 орчим хувь, 2016 оны эцэст 1-3 хувьд хүрч, түүнээс хойш нэмэгдэх төлөвтэй байна. Хүнсний болон хүнсний бус инфляци хоёул буурсны улмаас инфляци 2015-2016 онуудад саарах төлөвтэй байна.

МБСГ-ын зүгээс эдийн засгийн дотоод болон гадаад тэнцвэрийг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой бодлогын хэд хэдэн арга хэмжээг танилцуулж, мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх саналыг дэвшүүлэв.

МБЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар МБЗ-ийн гишүүд Бодлогын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөлөө.

Мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэхэд болгоомжтой хандаж байсан гишүүд Бодлогын хүү, ЗБН-ийн хувь хэмжээг зэрэг бууруулснаар чөлөөлөгдөх төгрөгийн эх үүсвэр нь гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлэх замаар гадаад тэнцэлд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхааруулсан. Улмаар Монголбанк валютын захад оролцох замаар төгрөгийг буцаан татсан тохиолдолд мөнгөний бодлогыг зөөлрүүлсний эдийн засаг дахь нөлөөлөл сулрахыг дурдсан. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр (захиргааны шинжтэй

хязгаарлалт)-ээс шалтгаалан банкуудын хувийн хэвшлийн зээлийн өсөлтийг дэмжих сонголтыг үгүй хийж, банкууд үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл шинээр гаргахгүй байна. Энэ мэт эдийн засгийн бус хязгаарлалт нь мөнгөний бодлогын ямар ч шийдвэрийн нөлөөллийг сулруулахаар байна. Мөнгөний бодлогыг зөөлрүүлэх нь бодит сектор, хувийн хэвшил дэх нөлөөлөл сул байх атлаа санхүүгийн секторт нэмэлт байдлаар эрсдэл үүсгэх, гадаад тэнцвэрт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн улсын төсөв, төлбөрийн тэнцэлд эерэг өөрчлөлт гараагүй, эдийн засгийн тэнцвэрийг хангах шаардлага хэвээр байгаа үед энэхүү шийдвэр нь зах зээлд ямар дохио өгөх талаар зөвлөлийн зарим гишүүд болгоомжилж байлаа.

Харин мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэхийг дэмжиж байсан гишүүд хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин огцом бууран 2015 оны 11-р сарын байдлаар 1.9 нэгж хувьд хүрсэн, инфляцийн суурь төсөөллөөр 2015, 2016 онд Төв банкны зорилтот түвшнээс доогуур байхаар хүлээгдэж байгаа нь мөнгөний бодлогыг тэлэх орон зай үүссэн гэдгийг онцолсон. Мөнгөний уламжлалт болон уламжлалт бус бодлогын хүрээнд хийгдсэн мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2014 оны сүүлийн улирлаас эхлэн буурч, сүүлийн саруудад мөнгөний нийлүүлэлт буурч, валютын зах тогтвортой байгаа нь бодлогын орон зайг олгож байна. Түүнчлэн 2016 онд мөнгө, зээлийн үзүүлэлтүүд дорвитой өсөх хандлага ажиглагдахгүй байгаа тул эдийн засгийн идэвхжилийг дэмжих нь чухал, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөвт эерэг хандлага гарч байгаа учраас мөнгөний бодлогын төлөвийг алгуур зөөлрүүлэх боломж үүсч байна гэсэн байр суурийг илэрхийлэв.

МБСГ-ын саналыг дэмжсэн гишүүд орон сууцны үнэ буурсаар байгаа нь банкны системд эрсдэл үүсч болзошгүйг харуулж байна гэж дүгнэж байна. Үл хөдлөх болон барилгын салбар нь нийт зээлийн багцын 40 гаруй хувийг эзэлдэг бөгөөд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлснээр нийт системийн тогтворжилтод эерэгээр нөлөөлнө. Зээлийн тархалт жигд биш энэ үед төгрөгийн заавал байлгах нөөцийг бууруулах, бодлогын хүүг бууруулах арга хэмжээг хослуулан авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэйг зарим гишүүд онцолсон.

Эдийн засгийн өсөлт 2015-2016 онд саарч, том дүнтэй гадаад өрийн эргэн төлөлт хийх хугацаа ойртож байгаа үед эдийн засгийн дотоод болон гадаад тэнцвэрийг хангах, макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авах шаардлагатай гэдгийг тэдгээр гишүүд онцолсон.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогыг зөөлрүүлэх саналыг тал бүрээс нь авч үзэн хэлэлцсэний эцэст Мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах томъёоллоор санал хураахад МБЗ-ийн гишүүдийн олонхын саналаар Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулахаар шийдвэрлэв.

Мөнгөний бодлогын мэдэгдэлд “нийлүүлэлтийн гаралтай инфляци нам, тогтвортой байхын зэрэгцээ эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт бага түвшинд байх төлөвтэй байна. Мөнгөний бодлогын төлөвийг алгуур зөөлрүүлэх энэхүү шийдвэр нь мөнгө, зээлийн өсөлт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд эергээр нөлөөлнө” гэсэн хандлагыг тусгах нь зүйтэй гэснээр МБЗ-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 12.0 хувь болгох шийдвэр гаргасан. Мөнгөний бодлогын шийдвэрийг 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.